

АГУУЛГА

НЭГ. “ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Төслийн талбай түүний орчны байгаль орчны төлөв байдал.....	5
2.2. Төслийн талбай түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдал.....	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .7	
3.1. “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн үйл ажиллагааны гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	7
3.1.1. Агаар орчин	7
3.1.2. Хөрсөн бүрхэвч.....	7
3.1.3. Усан орчин	7
3.1.4. Ургамлан нөмрөг	7
3.2. Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл үргэлжлэх хугацаа	7
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	10
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам	17
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	19
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ21	

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	19
Хүснэгт 7. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	20
Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	21
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2025 оны төсөв	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Шангри-Ла цогцолбор	3
------------------------------------	---

НЭГ. “ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК нь 2007 онд байгуулагдсан. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 1-р хорооны нутаг дэвсгэрт, Гэрлэх ёслолын ордны урд, Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хажууд байрладаг.

Гадаадын хөрөнгө оруулалттай “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК нь Дэлхийн томоохон хотуудад 100 орчим сүлжээтэй Шангри-Ла төв нь 5 одтой зочид буудал, А зэрэглэлийн оффис, худалдааны төв, тансаг зэрэглэлийн орон сууц, бүрэн тоноглогдсон спорт клуб хүүхэд багачуудад зориулсан адал явдлын бүс буюу тоглоомын төв зэргээс бүрдсэн 400 орчим автомашины зогсоолтой цогцолбор бүтээн байгуулалт бөгөөд худалдааны төв, оффис, тоглоомын төв, орон сууц, спорт клуб, зочид буудал зэрэг үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 1. Шангри-Ла цогцолбор

Худалдааны төв: Монголын хамгийн том, олон улсын жишигт нийцсэн худалдаа үйлчилгээний төв бөгөөд 27 мян.м² талбайг хамарсан үндэсний болон дэлхийн хэмжээний 200 гаруй брендүүдийг нэг дор багтаасан худалдааны, үйлчилгээний төв, IMAX кино театр, орон орны хоолтой ресторантай.

Оффис: Дээд зэрэглэлийн орчин үеийн шинэ технологиудыг өргөнөөр нэвтрүүлсэн, хамгийн сүүлийн үеийн дизайны шийдэлтэй.

Орон сууц: Цогцолборын нэгэн хэсэг болсон “Шангри-Ла Резиденс” орон сууц нь төвийн 6-33 дугаар давхарт байрлалтай, 6 хүртэлх өрөөний сонголттой.

Өндөр стандартын дагуу баригдсан, газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй, бүх байрандаа агаар шүүгчтэй, 24 цагийн харуул хамгаалалт, харилцагчийн инженерийн үйлчилгээ, өндөр хурдны лифт, гурван давхар шилэн фасадтай цонх, халаалтын систем тохируулагчтай.

Спорт клуб: Тав тухтай бялдаржуулах төв, спиннинг студи, иог, усан бассейн, саун, жакузигаас бүрдсэн цогц спорт клуб нь төвийн 3-5 давхарт байрлалтай.

Тоглоомын төв: 12 хүртлэх насны хүүхдүүдэд зориулагдсан аюулгүй орчинг бүрэн хангасан, тоглож наадах, амрах, танин мэдэхүйн цогц орчин бүрдүүлсэн адал явдлын бүс нь төвийн 3 давхарт байрлалтай, 5.5-7.3 метрийн өндөр 3 төрлийн гулсуур, үдэшлэг, баяр ёслолын өрөө, гэр бүлийн баяцхан тосгон зэргийг багцласан тоглоомын төвтэй.

Зочид буудал: Дэлхийн жишигт нийцсэн тэргүүлэх 5 одтой зочид буудал гэдгээрээ алдартай. Дээд зэрэглэлийн 6 төрлийн сонголттой 290 буудлын өрөө, 4 ресторан, лоунж, хотын хамгийн том хүлээн авалтын их танхим болон 8 жижиг танхимтай.

Цогцолборын хэмжээнд 10 нэр төрлийн химийн бодисыг хими цэвэрлэгээ, зочид буудлын угаалга, ариутгал, спорт клуб, уурын болон усан халаалтын зуухны арчилгаа, цэвэрлэгээнд ашигладаг. Химийн бодис ашигдах тусгай зөвшөөрөлтэй.

Нийт 692 ажилчинтай, жилд 365 хоног, 12/24 ээлжээр ажилладаг байна.

2025 оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, орчны хяналт шинжилгээний үзүүлэлтүүд тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хамт тусгасан болно.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбай түүний орчны байгаль орчны төлөв байдал

Цаг уур: Төслийн хувьд хэрэгжих орчин нь эрс тэс уур амьсгалтай, агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай, тухайн орчны агаарын хуурайшилт эрчимжиж байна.

Агаарын чанар: Уг төсөл хэрэгжих талбай нь хүн амын суурьшлын бүсэд шигүү бүтэцтэй, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй тул төсөл хэрэгжих талбайн орчмын агаар нь цэвэр болно.

Гадаргын болон гүний ус: Дүүргийн нутаг нь физик газарзүйн хувьд өмнөт Сибирь, Хангай-Хэнтийн уулт мужийн Онон-Хэнтийн уулын тайга-хотгорын дэд мужид, далайн түвшнээс дээш 1238~1456м өндөрт байрлана.

Нийслэл хот усзүйн сүлжээний хувьд Туул голын сав газарт хамаардаг. Төслийн талбайд хамгийн ойр орших гадаргын ус нь зүүн зүгт 600м орчим зайд урсах Сэлбэ гол юм.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбайд бүсийн тал газар хөндий хотгорын хөрсний бүлгийн, хархүрэн хөрс тархах боловч эзэмшил газар түүний ойр орчим хотжилтын нөлөөнд бүрэн өртөж хөрс бүтцээ алдсан, ихээхэн эвдрэлд орсон. Талбайн хөрсийг битүү цементлэсэн байна.

Ургамлан нөмрөг: Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар нийслэл хот Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн хоёр тойргын уулзвар нутагт оршдог. Сүхбаатар дүүргийн нутаг хойд болон төв(хотын төв) хэсгээр бэлчээрийн хэв шинжгүй, дунд хэсгээр уулын ой, уулын хээрийн нуга бол Чингэлтэй дүүрэгтэй хил залгах буюу баруун хэсгээр уул хоорондын болон хөндий нам дор газрын бэлчээрийн шинжтэй.

Амьтны аймаг: Улаанбаатар хотын төвд байрлалтай тул төслийн орчинд амьтны аймаг байхгүй.

2.2. Төслийн талбай түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдал

Улаанбаатар хотын төвд орших тус дүүрэг 21.8 мянган га газар нутагтай, 2010 оны эцсээр 20 хороо, 36,165 өрхтэй, 136,891 хүн амтай байв. Үүний хамт тус дүүрэгт нийслэлийн төр, засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны төв байгууллагууд төвлөрөн үйл ажиллагаа явуулж байдаг онцлогтой. Үүнд, Төрийн ордон, 13 орны элчин сайдын яам, Засгийн газрын яамд, Дэлхийн банк, НҮБ-ын Хөгжлийн

**“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ,
ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөтөлбөр, Хөгжлийн Банк Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль зэрэг орно.

“Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн төслийн үйл ажиллагаанд тус дүүрэг төдийгүй Улаанбаатар хотын иргэдийг ажлын байраар хангах, хотын иргэдэд цэвэрхэн, чанартай, дээд зэрэглэлийн үйлчилгээг үзүүлэх зэрэг эерэг нөлөөлөл үзүүлнэ.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн үйл ажиллагааны гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд

3.1.1. Агаар орчин

Агаар орчныг бохирдуулах үндсэн эх үүсвэр нь зуухны шаталтаас ялгарах бохирдуулагч хий юм. БНХАУ-ын “Fulton” брендийн FBD-5.6 маркийн зуух ашигладаг бөгөөд зуух нь бүрэн автомат системтэй, программаар ажилладаг. Зочид буудлын угаалга, агааржуулагч төхөөрөмжинд уур ашиглана.

3.1.2. Хөрсөн бүрхэвч

Химийн бодисын сав баглаа боодол, үлдэгдэл бодисыг хөрсөн дээр ил задгай асгавал, мөн дизель түлшний нөөцлүүр савны шугам хоолой, хаалт, хавхлага гэмтэх, саванд цооролт үүсэх, шугам хоолой задрах, зэрэг шалтгаанаас үүдэн дизель түлш хөрсөнд алдагдах, хөрсийг бохирдуулж болзошгүй.

3.1.3. Усан орчин

Гадаргын болон гүний усанд газрын тосны бүтээгдэхүүн алдагдвал тухайн бүтээгдэхүүний гадаргуугийн шинж чанараас хамааран усны гадаргуу дээр янз бүрийн хэмжээтэй (плёнка) хальс үүсгэн тогтох ба энэ нь удаан хугацаагаар байвал усан дахь хүчилтөрөгчтэй исэлдэж ууссан хүчилтөрөгчийн хэмжээг багасгаж, усны амьд организмуудын амьдралын орчинд сөргөөр нөлөөлөх мөн хартугалга зэрэг хортой хүнд металлуудын бохирдлыг үүсгэдэг.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт томоохон гол, мөрөн, нуур байхгүй тул гадаргын усанд шууд байдлаар сөргөөр нөлөөлөхгүй.

3.1.4. Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжих талбай нь битүү цементэлсэн, зам, зарим хэсэгт ногоон байгууламжтай, байгалийн төрхөөрөө байгаа ургамал болон амьтан байхгүй тул шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.2. Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл үргэлжлэх хугацаа

“Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны тэнцвэрийг алдагдуулах сөрөг нөлөөлөлд дараах зүйлс орж байна. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэх явцад хүмүүс байгаль орчинтойгоо хайнга харьцсанаас хүрээлэн буй орчин гадны нөлөөнд нэн хялбар өртөж алдралд орох, улмаар байгалийн амьд хүчин зүйлс дахин сэргэхгүйгээр устах, байгалийн унаган төрх өөрчлөгдөж түүний хөгжлийн хэвийн жам алдагдахад хүргэдэг. Үүнтэй уялдан экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах сөрөг нөлөөлөл үзүүлж болох эх үүсвэрүүдэд дараах зүйлс орно. Үүнд:

- Байгалийн хүчин зүйлүүдийг дутуу үнэлэх,
- Байгаль орчныг хэт бохирдуулах,
- Гал түймэр,
- Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол,

Энэ бүхэн нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээгүйтэй холбоотой юм. Иймд экологийн тэнцвэрт байдлыг алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд:

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод, бут тарих
- БОННУ-ний БОМТ (ОХШХ) –нд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад бохирдуулагч бодисын хэмжилтийг тогтмол хугацаанд хийж, төслийн талбайн орчны агаарын бохирдолтыг хянах, агаар бохирдуулагч бодисуудыг ЗДХ-ээс хэтрүүлэхгүй байх;
- Гал түймрийн аюулаас ямагт сэрэмжилж, урьдчилсан арга хэмжээ төлөвлөх, галын булангийн нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр тогтмол шинэчлэх;
- Хатуу хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх, хог хаягдлын ангилан ялгадар болох;
- Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах
- Химийн бодисын хаягдал хөрс, ургамалд хаягдахаас урьдчилан сэргийлэх
- Химийн бодистой ойрхон ажилладаг ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах, анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр), сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээний зөвлөмжид тусгасан арга

хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг тусгай ажилтанд хариуцуулж, биелэлтэд нь удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж ажиллах;

- Төслөөс ажилчдын эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх, ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр бүрэн хангах хэрэгтэй.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдэд шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах байгаль орчны үндсэн баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Энэхүү БОМТ нь Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид агаарын чанар, газрын доорх ус, хөрсний чанарт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, тэмдэглэл хөтлөж мэргэжлийн шинжээч, судлаач, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

БОМТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийнэ. БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний дотор Нийслэлийн БОГ-т тайлагнаж, дараа жил хийх ажлын төлөвлөгөөг БОУАӨЯ-аар батлуулж ажиллана.

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
		1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Агаар орчин	Агаарын бохирдлыг бууруулах	Агааржуулалтын филтерийг угааж шаардлагатай тохиолдолд солих	Улирал бүр	Удаа	15,000.0	4	60,000.0	2025 онд	Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010-2001	
2.	Усны нөөц, чанар	Усыг хэмнэлттэй ашиглах, стандартад нийцсэн усаар хангах	Ус ашиглах зөвшөөрөл авч, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Жил бүр	-	-	-	-	1 дүгээр улиралд	Усны тухай хууль	
3.			Төслийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал усны дүгнэлтийг 2025 оны эхний улиралд багтаан гаргуулах	Төслийн явцад	-	-	-	-	2025 онд	Усны тухай хууль	
4.			Ус ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх	Сар бүр	-	3,500.0	12	42,000.0	2025 онд	Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Татварын хэлтэст төлөх Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт. MNS 0900:2018	
5.			Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах	Жил бүр	-	-	-	-	2025 онд		
6.			Усан спортын төвд ашигласан усыг элсэн филтерээр шүүж, ионжуулагчаар нян, бактерийг устгаж эргүүлэн ашиглах	Төслийн явцад	-	-	-	Гэрээний дагуу	2025 онд		
7.				Ус ашиглалтын тайланг Усны газарт хүргүүлэх	Жил бүр	-	-	-	-	2025 онд	https://ewater.mn
8.			Хөрс, ургамлан бүрхэвч	Химийн бодис алдагдаж хөрс, ургамлан нөмрөгийн	Ургамалжсан талбайг арчлах, хамгаалах хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж ажиллах	-	-	-	-	2,000.0	2025 онд

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

9.	бохирдол үүсэхээс сэргийлж ажиллана.	Эзэмшил газар болон ойр орчмын 50м-т байгаа нийтийн эзэмшлийн зам, талбайн арчилгаа хийх	-	-	-	-	-	2025 онд		
10.		Эзэмшил газрын төлбөрийг хуулийн дагуу тогтоосон хугацаанд тогтмол төлөх	-	-	-	-	Гэрээний дагуу	2025.12.15 -ны дотор	Газрын төлбөрийн тухай хууль	
11.		Эзэмшил талбай дотор ил задгай хог хаягдлыг цэвэрлэх, дахин үүсгэхгүй байх	-	-	-	-	-	2025 онд	Хог хаягдлын тухай хууль	
12.		Хатуу хог болон аюултай хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх	-	-	-	-	-	2025 онд	Хог хаягдлын тухай хууль	
Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал, мян.төг								104,000. 0		

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Гадна ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоог гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналт тавих	Гадна ногоон байгууламжийг арчлах, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт хийх	Ногоон байгууламжийн арчилгаа, тордолтыг хийх	-	-	-	Гэрээний дагуу	Зуны турш	
	Нийт						4,000.0		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Археологи, палентологийн дурсгал	Ашиглаж буй газар нь Улаанбаатар хотын төвд байрлах бөгөөд хатуу хучилттай талбайтай тул археологи, палентлогийн дурсгал байхгүй.	-	-	-	-	-	-
Нийт зардал				-	-	-	-	-

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрдлүүд	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам зааврыг мөрдөх	ХАБЭА-н дүрэм зааврыг мөрдөж ажиллах, ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах	Химийн бодистой харьцдаг ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах	Холбогдох ажилчид	Жилд 1 удаа	-	Гэрээний дагуу	2025 онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль MNS 6458 : 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам зааврыг мөрдөх	ХАБЭА-н дүрэм зааврыг мөрдөж ажиллах, ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах	Химийн бодистой харьцдаг ажилчдын ажлын хувцас, нэг удаагийн хамгаалах хэрэглэлээр хангах		Жилд 1 удаа	-	Гэрээний дагуу	2025 онд	
3	Химийн бодисын эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал эрсдэлд орох	Химийн бодисын агуулахыг MNS 6458:2014 стандартад Нийцүүлэн тохижуулах	Химийн бодисын агуулах	-	-	-	2025 онд	
			Химийн бодисын асгаралтын иж бүрдэл авах	Химийн бодисын агуулах	-	-	-	2025 онд	
			Химийн бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хангах, тээвэрлэлт, хадгалалтын ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэх	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчид	Тухай бүр	-	Гэрээний дагуу	2025 онд	
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдэлийн сан үүсгэх,	-	4000.0	2025 онд						

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

			байнгын бэлэн байдалд байлгах							
4			Шангри-Ла академиас зохион байгуулдаг аюулгүй ажиллагааны сургалтад зорилтот ажилчдыг хамруулах			-	-	2025 онд		
5			Хөдөлмөр хамгааллын сургалт улиралд 1 явуулах			-	-	2025 онд		
6	Галын аюулгүй байдал	Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх	Химийн бодисын агуулахад гал унтраах багаж хэрэгслийг бүрэн байлгах	Химийн бодисын агуулах		-	-	2000.0	2025 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт								6000.0		

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн хаягдал	Энгийн хог хаягдал тээвэрлэн зайлуулах гэрээг шинэчлэн байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаанаас гарах энгийн хог хаягдал	Удаа	100.0	12	1,200.0	2025 он	Хог хаягдлын тухай хууль, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015
2.		Хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай савнуудыг хүртээмжтэй байрлуулж хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж хэвшүүлэх		-	150.0	10	1,500.0	2025 он	
3.		Хог хаягдлыг бууруулах, ангилах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	-	-	-	-	2025 он	
4.		Эзэмшил талбай, түүний ойр орчимд ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж, цэвэрлэх	Төслийн явцад	-	-	-	49,200.0	2025 он	
5.		Хог хаягдлыг ангилан ялгах системийн үр дүнг хянах, хаягдлын хэмжээ, дахин боловсруулагдсан хаягдал, устгагдсан хаягдал зэргийг тодорхойлж, бүртгэлжүүлэх, устгал, зайлуулалтад байнгын хяналт тавих	Удирдлага, зохион байгуулалт	-	-	-	-	2025 он	
6.	Аюултай хаягдал	Химийн бодисын савыг байгаль орчин бохирдуулахаас сэргийлж, гэрээт байгууллагад нийлүүлэх	Төслийн явцад	-	-	-	-	2025 он	
7.		Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөх, устгасан талаар акт үйлдэх, аюултай хог хаягдлын төлбөр төлөх		-	-	-	Гэрээний дагуу	2025 он	
8.		Аюултай хог хаягдал хариусан ажилтантай болох	Удирдлага, зохион байгуулалт	-	-	-	-	2025 он	
9.	Шингэн хаягдал	Гал тогооноос гарч буй хаягдал тосыг тос баригчаар цэвэршүүлж, гэрээт байгууллагаар цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэх, хяналт тавих	Үйл ажиллагаанаас гарах тосны хаягдал	Удаа	9,000.0	12	108,000.0	2025 он	

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.	Усан спортын төвд ашигласан усыг элсэн филтерээр шүүж гарсан хаягдлыг төвийн шугамд нийлүүлэх	Усан спортын төвийн ус	-	-	-	Гэрээт байгууллага ар	2025 онд	
Нийт зардал						159,900.0		

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Байгаль орчны бүрдлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1	Гадаргын болон газрын доорх ус	Хэрэглээний усны чанар, найрлагыг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	Хэрэглээний ус	Жилд 4 удаа	4	86.7	346.8	Итгэмжлэгдсэн лабораториор	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт. MNS 0900:2018
2	Гадаргын болон газрын доорх ус	Үйл ажиллагаанаас гарч буй ахуйн шингэн хаягдлаас дээж авч шинжилгээ хийлгэх	Хаягдал ус	Улиралд 8 удаа	8	100.0	800.0	Итгэмжлэгдсэн лабораториор	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015
		Нийт					1,146.8		

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			сар	сар	сар		
	1	2	3	4	5	6	7
1.	“Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны холбогдолтой зөвшөөрөл, гэрээнүүд/газар ашиглах, ус ашиглах гэрээ, хог тээвэрлэлтийн гэрээ, ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглуулах дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, дүгнэлт, галын дүгнэлт, аюултай хог хаягдал зайлуулах гэрээ г.м/-ийг цаг хугацаанд нь чанартай биелүүлж дүгнүүлэх, сунгах, холбогдох төлбөр тооцоог хийх	-	-	-	-	Захирал	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль эрх зүй
2.	Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан мэдээг Сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлэх	-	2025-01 сард		2025-11-15-ны дотор	Химийн бодис хариуцсан мэргэжилтэн	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
3.	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, байгаль орчны мэргэжилтэнтэй болох	-	-	-	-	Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл
4.	MNS 4219:1994 Байгаль орчны хамгаалал Аж ахуй нэгжийн экологийн паспортыг хөтлөх	-	-	-	-	Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
5.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх	-	-	-	-	Захирал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
6.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	-	-	-	-	Захирал	Галын аюулгүй байдлын тухай хууль
7.	Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Гэрээний дагуу					Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Нийт зардал		00.0					

“ШАНГРИ-ЛА УЛААНБААТАР ХОТЕЛ” ХХК-ИЙН “ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нийслэлийн БОГ-т	БОМТ-ий тайланг цахимаар илгээж, дүгнүүлэх	БОМТ-ий биелэлт	4-р улиралд	100.0	БО-ны асуудал хариуцсан ажилтан	Төсөл хэрэгжүүлэгч
2	БОУАӨЯ-нд	БОМТ-ий тайлан, төлөвлөгөөг цахимаар илгээж батлуулах	БОМТ-ий биелэлтийг 11 сарын 01-ний дотор, төлөвлөгөөг 12-р сарын 31-ээс өмнө	4-р улиралд	100.0	БО-ны асуудал хариуцсан ажилтан	Төсөл хэрэгжүүлэгч
Нийт					200.0		

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2025 оны төсөв

№	Зардлын ангилал	Төсөв, мян.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	104,000.0
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0.0
3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0.0
4.	Осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	6,000.0
5.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	159,900.0
6.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	1,146.8
7.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0.0
8.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200.0
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв, мян.төг		271,246.8

“Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн хэрэгжүүлэх 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **271,246.8 мянган төгрөг** зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.